



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар А/476

Моран сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 “а”, Монгол улсын Засгийн Газрын 2016 оны 193 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Захиалагчийн хяналтын зардлыг зарцуулах, тайлагнах журам батлах тухай” 2018 оны 57 дугаар тогтоолын 3 дугаар бүлгийн 3.11 дэх хэсгийг тус тус үндсэлэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Барилга байгууламжийн чанар байдалд дахин үнэлгээ хийх 2 өдрийн сургалтанд оролцох төрийн албан хаагчид, Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн ажилтнуудад шаардлагатай 1,000,000 (Нэг сая) төгрөгийг барилга байгууламжийн захиалагчийн хяналтын зардлаас санхүүжүүлсүгэй.

2. Сургалтанд оролцогчдод цай өгөхөд шаардагдах зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн даргад(Г.Сувд)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Л.ГАНБОЛД